



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 1/44

Сант сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын малын тоо толгойн албан татвараар санхүүжигдэн хийгдэж буй "Мухар бүдүүнд мал угаалгын ваннтай болох"-ын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Золбаяр

(Хушаат багийн Засаг дарга)

Гишүүд:

Ц.Батсайхан

(Газрын даамал)

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн багийн Засаг дарга)

Г.Анхбаяр

(Тархвар зүйч)

Ө.Ганбаатар

(Малын эмч)

2. Ажлын гэрээний үүргийн биелэлтийн чанар болон гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Золбаяр)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

d/disk 2023 on zahiramj

43151044

Боловсруулсан: *З. Дунгарма*
Хянасан: *В. Агваарал*
Хувь: *2*
Огноо: *2023-07-10*